



**Ж. Эрдэнэчимэг**

Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч, Жендэрийн тэгш байдлын асуудлаархи Үндэсний Зөвлөлийн дэргэдэх шинжээч багийн гишүүн Жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах чадавхийг бэхжүүлэх төслийн Үндэсний зөвлөх "Монголжингоо" сонины эрхлэгч

**УЛС ТӨР, НИЙГМИЙН АМЬДРАЛД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО СУЛ, ЭРХ МЭДЭЛ БАГА БАЙНА**

Жендерийн эрх, тэгш байдлын талаар хийсэн ярилцлага

**Жендэрийн тэгш эрх, тэгш байдлын талаар ихээхэн яригдах боллоо. Энэ талаар Таны бодол ?**

Хүний нийгмийн хөгжил цаашдаа ямар замаар явах вэ? Хэрэв төлөвлөж, залж болох бол юунд үндэслэж, яаж хэрэгжүүлэх вэ? гэдэгтэй холбогдож харьцангуй шинэлэг хэлбэрээр гарч ирсэн үзэл баримтлал юм. Хүний нийгэмд харьцангуй тогтвортой ялгаанууд байна. Энэ бол үндэстний ялгаа, орлогын ялгаа, бас хүйсийн ялгаа. Чухамхүү энэ хүйсийн ялгаан дээр үндэслэж, үзэл суртлаар бэхжигдсэн нийгмийн чиг үүргийн зохиомол ялгаварлал нь хүний бүтээлч хүсэл эрмэлзлэлийг боогдуулж, нэг нь нөгөөгөө дарлах, хөгжилд оролцох оролцоог хязгаарлах, улмаар хүний эрхийг боогдуулах, хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг өөгшүүлж байна гэж үзэж байгаа юм. За тэгээд аль хүйс нь илүү их дарлагдсан, хохирсон болж таардаг вэ гэхээр эмэгтэйчүүд. Тиймээс жендэрийн тэгш эрхийн асуудлыг ихэвчлэн эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг дээшлүүлэх асуудалтай холбон тавьдаг юм. Энэ үзэл баримтлалын дагуу нийгмийн харилцаан дахь жендэрийн тэгш бус байдлыг хүний ухамсар сэтгэлгээ болон ахуй амьдрал, нийгмийн олон талт харилцааны хүрээнд гэтлэн давсанаар тогтвортой хөгжлийг хангах, эдийн

засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах зэрэг хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үздэг юм .Би бас энэ үзлийг дэмждэг.

**Манай улсад харин ч эмэгтэйчүүд нь их эрхтэй, боловсролтой юм шиг яриад байдаг шүү дээ?**

Жендэрийн тэгш байдлын үзүүлэлтээр улс орон бүр харилцан адилгүй байдаг юм байна. Жишээ нь, Монголын Хүний Хөгжлийн илтгэлд дурдсанаар 2002 оны байдлаар манай Жендэрийн хөгжлийн индекс /ЖХИ/- нь 0.679 байгаа юм. Үүнийг тус улсын Хүний хөгжлийн индекс болон дэлхийн зарим ижил төстэй хөгжлийн түвшин бүхий улс оронтой харьцуулахад бас ч гайгүй байна гэж үзэж байгаа. ЖХИ-д дундаж наслалт, насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалт, бүх шатны сургуульд хамрагдалт, нэг хүнд ноогдох ДНБ зэрэг үзүүлэлтийг харьцуулж авч үзсэн байна. Эдгээрээс боловсролын тэгшитгэсэн индекс 0.884 буюу бусад үзүүлэлтээс хамаагүй өндөр байгаа юм. Энэ нь манай иргэд хүйсийн хувьд боловсрол олж авах тал дээр адил тэгш боломжтойгоор барахгүй охид, эмэгтэйчүүд нь илүү суралцаж байна гэсэн үг. Эрхийн хувьд авч үзвэл, тухайлбал, жендэрийн эрх мэдлийн хэмжүүр /ЖЭМХ/ -ээр нилээд доогуур түвшинд гарсан байна. Энэ бол улс төр, эдийн засгийн амьдрал дахь оролцоог илтгэдэг үзүүлэлт бөгөөд 2002 оны байдлаар 0.458 байгаа нь улс төр, нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоо сул, эрх мэдэл бага байгааг харуулж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл, олж авсан боловсролоо борлуулах, үр шимийг нь өөртөө болон нийгэмд хүртээх боломж хязгаарлагдмал, аливаа асуудлыг шийдвэрлэхэд саналыг нь бага сонсдог, ажил албан тушаал ховор олддог, энэ утгаараа орлого багатай, ядуу байна гэж ойлгож болно. Бүх айлд эхнэр нь мөнгөө барьдаг чинь эрх мэдэл биш үү гэж ихэнх хүмүүс хэлээд байдаг юм. Дийлэнх хэсгийн хувьд амьдралд хүрэлцэхгүй, бараг байхгүй шахуу орлогыг барина гэдэг чинь эрх мэдэл бус боолчлол гээд хэлчихвэл нэг их хилсдэхгүй болов уу. Харин цалин орлогоо өөрсдөө бий болгоод түүнийгээ өөртөө төдийгүй олон түмэн, нийгмийн сайн сайхны төлөө захиран зарцуулах эрх мэдэл бүхий цөөн ч гэсэн оюунлаг, чадварлаг эмэгтэйчүүд бас бий. Энэ бол нийгэмд байгаа боломжийг зөв ашиглаж өөрийгөө хөгжүүлэхийн чухлыг бас сургаж байгаа юм.

**Жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулна гэж яригдаж байна. Энэ талаар юу хийгдэж байна вэ?**

Ер нь аливаа асуудалд жендэрийн дүн шинжилгээ /анализ/ хийнэ гэдэг нь харьцуулсан судалгаа шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож бодлого шийдвэрт тусгаж, ажил амьдралыг сайжруулах зорилготой. Улсын төсөв гэдэг бол

нэг талаасаа эрх барьж буй улс төрийн хүчний нийгэм-эдийн засгийн бодлогыг илэрхийлэх чухал баримт бичиг, бас тэдний бодлогоо хэрэгжүүлэх арга хэрэгслэл. Улсын төсөвтөө жөндөрийн мэдрэмжийн үнэлгээ хийх аргыг харьцангуй өндөр хөгжилтэй улс оронд анх санаачилж, тэр нь дэлхий нийтэд түгэн тархаж байна. Манай улс ч энэ талаар хоцроод байхыг хүсэлгүй НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр төсөвт жөндөрийн үнэлгээ хийх арга барилд суралцаж эхлээд байна. СЭЗЯ-ны Ядуурлын Судалгааны Нэгж энэ ажлыг хариуцаж байна. Манай төрийн сан, төсвийн мэргэжилтнүүд, салбарын яамд, орон нутгийн захиргаад иргэний байгууллагатай хамтран төсвөө авч үзэх бүх шатанд жөндөрийн нөлөөллийг дүгнэж ярилцдаг болно гэж бодож байна. Яагаад гэвэл энэ нь макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахын тулд хүний хөгжлийг хангах, нийгмийн шударга ёсыг бүрдүүлэх үндэсний бодлого зорилттой нийцэж байгаа юм.

#### **Энэ ажлыг юунаас эхлэх вэ?**

Суралцахаас. Судлахаас. Төсөвт жөндөрийн дүн шинжилгээ хийдэг арга ажиллагааг танин мэдэж тодорхой салбарын юм уу, орон нутгийн төсвөөс эхлэн судалж, дүгнэлт гаргах хэрэгтэй болж байна. Энэ ажилд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах талаар олон улсын байгууллагууд, түүний дотор Дэлхийн банкны Итгэлцлийн сан санал санаачлага гаргасан байна. Мөн танай сэтгүүлийн энэ дугаарт "Иргэний нийгмийн төсвийн санаачлага" хэмээх олон улсын байгууллагаас зарласан төслийн зарлалыг тавьсан байна лээ. Энэ төсөлд ТББ болон иргэний нийгмийн байгууллагууд өргөнөөр оролцоосой гэж уриалмаар байна.

**Манай улс Жөндөрийн тэгш байдлыг хангах Үндэсний Хөтөлбөртэй болсон. Үндэсний Зөвлөл үүнийг хэрэгжүүлдэг юм байна. Энэ чиглэлд ямар нэг ахиц дэвшил байгаа юу?**

Байгаа гэж бодож байна. Цаашдаа ч боловсронгуй болгох, хэрэгжүүлэх ажил их бий. Гэхдээ энэ ажил бол зөвхөн Үндэсний Зөвлөлийн ажил бус. Төр, засгийн байгууллагууд иргэний нийгэмтэй түншлэлийн гэрээгээр хийх асар их ажил бий. Үндэсний Зөвлөл нь санаачлагч, идэвхижүүлэгч, зохион байгуулагч, хяналт-үнэлгээ хийгч гол байр суурин дээр байхаас аргагүй. Тухайлбал, Жөндөрийн тэгш эрхийн хууль хэрэгтэй гэж бодож байна. Олон нийт, мэргэжилтнүүд, бүх шатны удирдлагад хандсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлууд шаардлагатай. Хамгийн гол нь нөхцөл байдлын болон

бодлогын судалгаа, дүн шинжилгээний арга барилд суралцаж, зүгээр нэг яриад байх бус амьдралд хэрэг болгож хэрэгжүүлэх хэрэгтэй.

**Манай урилгыг хүлээн авч ярилцлага өгсөн Танд баярлалаа. Амжилт хүсье.**